



Та бүхэнд 2024 оны 06-р сард батлагдсан онцлох хууль, УИХ-ын болон Засгийн Газрын тогтоол, Ерөнхийлөгчийн Зарлигийг танилцуулж байна. 2024 оны 06-р сарын 05-ны УИХ-ын нэгдсэн чуулганы хаалтын өдөр нийтдээ 15 хууль батлагдсан байна.

Батлагдсан хууль

- ❖ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдан, 2025 оны 06-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.
- ❖ Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан. Уг хууль нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилготой.
 - Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
 - Хотын албан татварын тухай хууль
- ❖ Малчны тухай хууль батлагдсан. 2024 оны 06-р сарын 24-нөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Уг хууль нь малчдын эрх зүйн байдлыг тодорхойлж, дэмжих зорилготой.
 - Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
 - Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль

- Шүүх байгуулах тухай хууль батлагдсан. “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт заасан “иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг бий болгох, хараат бус, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан.
- ❖ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
- ❖ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- ❖ Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль
- ❖ Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль
- ❖ Биеийн тамир, спортын тухай хууль
- ❖ Монгол улсын нэгдэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль
- ❖ Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль

Батлагдсан УИХ-ын тогтоол

- ❖ 2024 оны 06-р сарын 06-ны өдрийн “Хот байгуулах тухай” №72 тогтоол
 - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдогдуулан улс болон орон нутгийн зэрэглэлтэй хотуудыг байгуулна.
- ❖ 2024 оны 06-р сарын 05-ны өдрийн “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт

хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” №62 тогтоол

- ❖ 2024 оны 06-р сарын 05-ны өдрийн “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” №63 тогтоол

- “Цагаан алт” хөдөлгөөнийг өрнүүлж, чиглэл чиглэлээр авах арга хэмжээнүүдийг тогтоосон байна.

Батлагдсан Засгийн газрын тогтоол

- ❖ 2024 оны 06-р сарын 06-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” №257 тогтоол

- “Цагдаагийн алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам” батлагдан, Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг таван жил тутам олгоно.

- ❖ 2024 оны 06-р сарын 16-ны өдөр, “Мөнгөн тусламжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” №255 тогтоол

- “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөгөөр, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 200,000 (хоёр зуун мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон.

Ерөнхийлөгчийн зарлиг

- ❖ 2024 оны 06-р сарын 10-ны Монгол улсын ерөнхийлөгчийн №84 зарлигаар
 - “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг баталсан.

Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл

- ❖ 2024 оны 06-р сарын 02-ны өдөр “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” төсөл
 - Аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс 1000 хүртэл км хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн албан татвар төлөгчийн жилийн орлогоос хамаарч, албан татварыг хөнгөлнө.
- ❖ 2024 оны 06-р сарын 03-ны өдөр “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” төсөл

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Pearl tower А блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 9511-3680